



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАШАА БАРИХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Булган аймгийн Могод сумын Эрүүл мэндийн төвийн хашаа барих. Хашааны нийт урт нь 400 м хэмжээтэй, төмөр хашаа барих. 1 ш авто хаалга, 3 ш явган хаалгатай байна.

- Хашааны өндөр нь 1.5 м, шон хоорондын зай нь 2 м байна. Хайс нь босоо савх төмрүүдтэй байх ба доод, дээд талдаа тус бүр хөндлөн дай төмөртэй байна.
- Хайс хоорондын шон нь 60×60 мм квадрат хөндий, төмрийн зузаан нь 3 мм байна. Шонг доош 50-60 см гүн суулгаж, цементлэх. Шон нь дээрээ тагтай байна.
- Савх төмөр нь 20×20 мм квадрат хөндий, төмрийн зузаан нь 1.5 мм байна. Хайсны савх төмөр хоорондын зай 12 см, босоо савх төмөр байна.
- Дай төмөр нь 40×20 мм квадрат хөндий, төмрийн зузаан нь 1.5 мм байна.
- Явган хаалга тус бүр өргөн нь 1.2 м, авто хаалга /гүйдэг том хаалга/-ны өргөн нь 4,5 м байна. Хаалга тус бүр чимэглэл, загвартай байна.
- Хашааны төмрийн өнгө нь "Хар" байна. Чимэглэлийн өнгө нь алтлаг шар байна.
- Хашааны гагнуурыг хийхдээ стандарт, норм дүрмийг баримтлах бөгөөд гагнуурын өө сэвийг сайтар цэвэрлэсний дараа будаг хийнэ.

-----oO-----